

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/555  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архивын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Архивын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Архивын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсвийн байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын дарга С.Энхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, анхан шатны иж бүрэн баримтаар дэмжигдсэн гүйлгээг зардлаар бүртгэж байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архивын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 12-ноос 2020 оны 2 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Б.Анармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24 ний өдрийн 01/48 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Архивын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Монгол төрийн ой санамж, түүх, соёлын үнэт баримтыг хадгалан хамгаалж, өнгөрснийг одоотой, одоог ирээдүйтэй холбон, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог олон улсын стандартад хүргэх"*-д оршино.

Архивын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсын үндэсний архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн ажлын талаар арга зүйн нэгдсэн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх.
- Архив, албан бичиг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, байгууллага, иргэдэд архивын лавлагааны үйлчилгээ үзүүлэх.
- Архивын сан хөмрөгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, архивын асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаад орнуудад Монгол улсын түүх соёлд холбогдох архивын баримтыг олж илрүүлэх, хуулбарлах, худалдан авах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Архивын ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acioius" программ хангамж ашигладаг байна.

Архивын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Архивын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 35 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн

санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,406,100.0 мянган төгрөгөөс тооцон 88,122.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Архивын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 803,090.2 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21.5	15,981.7	15,960.2
Авлага	8,050.2	10,257.4	2,207.2
Урьдчилж гарсан зардал	24,637.7	24,637.7	0
Бараа материал	394,200.3	361,411.1	(32,789.2)
Үндсэн хөрөнгө	16,283,756.4	15,495,288.0	(788,468.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,710,666.1</b>	<b>15,907,575.9</b>	<b>(803,090.2)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,710,666.1	15,907,575.9	(803,090.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>16,710,666.1</b>	<b>15,907,575.9</b>	<b>(803,090.2)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд цалингийн нийт зардлаас Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санд 22,056.4 мянган төгрөгийг тооцож, төрийн сангийн дансанд төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд “Бэмби сан” ХХК-д ном хэвлүүлэхээр төлбөрийг шилжүүлж, ном нь хэвлэгдэж гараагүйгээс авлага үүсгэсэн нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018-2019 онуудад үүссэн Юнивишн ХХК-ийн барьцааны 980.0 мянган төгрөг, Хан-уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 13.4 мянган төгрөг, Бэмби сан ХХК-тай ном хэвлэх төлбөрт шилжүүлсэн авлага 9,264.0 мянган төгрөгийн хэвийн авлага байна.

2018 онд архивын тоо бүртгэлийн программ хангамжийн системийн сайжруулалт, хөгжүүлэлтэд зориулж урьдчилж гарсан зардлаар 24,637.7 мянган төгрөг бүртгэсэн ба энэ ажил дуусаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд 25,456.4 мянган төгрөгийн шатахуун бодит хэрэгцээнээс илүү нөөцөлснийг тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд урд онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Харин 2017-2018 онуудад худалдан авсан 47 нэр төрлийн 87,461.5 мянган төгрөгийн бичиг хэргийн болон хангамжийн бараа материал ашиглагдаж байна. Оны эцэст 15,800.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж нөөц үүсгэсэн нь шатахууныг бодит хэрэгцээтэй уялдуулан төлөвлөөгүй, бэлтгэсэнээс бараа материалын үлдэгдлийг өсгөсөн байна. Батлагдсан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх үр дагавартай байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 179,399.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 115,317.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж данснаас хасалт хийсэн, хуримтлагдсан элэгдэл 41,696.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтаар 58,274.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 121,125.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дүн акталсан 115,317.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Биет бус хөрөнгө 10,362.0 мянган төгрөгөөр өссөн нь шинээр “СССКонсалтинг” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж “Лицензтэй программ хангамж” худалдан авсан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,907,575.9 мянган төгрөг болж 803,090.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагаанаас үүссэн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хуримтлагдсан элэгдлийн зардал, хөрөнгийн урсгал зардал, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, бараа материал акталсны зардал, гадаад, дотоодын томилолтын зардал зэрэг нь өмнөх оноос 139,101.3 мянган төгрөгөөр буюу 8,9 хувиар өссөнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Архивын ерөнхий газар нь тайлант онд 245,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 346,723.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 141.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	/мянган төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Лавлагаа үйлчилгээний орлого	80,000.0	105,743.4	25,743.4	132.2
Маягт, үнэт цаасны орлого	75,000.0	107,958.6	32,958.6	143.9
Архивын албан бичиг хөтлөлт болон бусад сургалтын орлого	90,000.0	133,021.0	43,021.0	147.8
<b>Нийт дүн</b>	<b>245,000.0</b>	<b>346,723.0</b>	<b>101,723.0</b>	<b>141.5</b>

Үндсэн үйл ажиллагааны орлого 101,723.0 мянган төгрөгөөр давж биелэхэд Засгийн Газрын “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 150 дугаар тогтоол гарч орон даяар архивын улсын үзлэг хийх болсонтой холбогдуулан архивын сургалт, болон маягтын орлого нэмэгдсэн нь шалтгаалсан байна. Архивын сургалтын болон маягтын орлогын төлөвлөгөө 165,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 240,979.6 мянган төгрөг буюу 46.0 хувиар давсан байна.

Тайлант онд 3,576,870.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,518,596.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 58,274.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3,331,870.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 245,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,412,640.2 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь гэрэл цахилгааны зардал 7,143.3 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардал 59,863.8 мянган төгрөг, бусад зардал 4,274.4 мянган төгрөг нийт 71,281.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна. Дутуу зарцуулсан 71,281.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан 101,723.0 мянган төгрөг нийт 173,004.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.



**Нэмэлт төсөв:** Халх голын 80 жилийн ойд зориулан 5,000.0 мянган төгрөгийг Батлан хамгаалах яамнаас нэмэлт санхүүжилтээр авч зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 35 эрсдэл тодорхойлж, нийт 35 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 125,228.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 102,039.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 23,189.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 албан шаардлага өглөө.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс тайлант онд 15,800.0 мянган төгрөгийн шатахууныг нэмж бэлтгэн, оны эцэст 17,090.0 мянган төгрөгийн шатахуун илүү нөөцөлсөн. Энэ нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### **Шийдвэрлэсэн нь:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, бараа материалын зохистой үлдэгдлийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дараах алдааг аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 –д заасныг үндэслэн залруулж ажилласан болно.

- Эд хогшил, тоног төхөөрөмж бүхий 71,078.4 мянган төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалд ангилал сольж бүртгэсэн. Энэ нь үнэн зөв, толилуулаг ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 388-р тушаалын 4.29-д заасан УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө" дагаж мөрдөнө гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Үндсэн үйл ажиллагааны зарим орлогыг (15,000.0 мянган төгрөгөөр) давхардуулж бүртгэсэн нь тухайн байгууллагад ашиглагдаж байгаа санхүүгийн программ болон нягтлан бодогчийн программын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Аудитаар илэрсэн 6,099.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Архивын ерөнхий газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 58 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн ангилал зориулалтыг зөрчиж дотоод томилолтын зардлаас шатахуун бэлтгэж, бодит хэрэгцээнээс илүү нөөцөлсөн зөрчлийг арилгаагүй, зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Архивын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 6,099.2 мянган төгрөгийн (*бичиг хэрэг, цэвэрлэгээний материалын худалдан авахдаа*) ажил гүйлгээ хийсэн. Энэ нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Анхан шатны дэмжих баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар зардлын гүйлгээ хийгдсэн байх.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны иж бүрэн баримтаар дэмжигдсэн гүйлгээг зардлаар бүртгэж байх, дотоод хяналтыг сайжруулах.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлыг хүлээн зөвшөөрч, баримтын бүрдлийг хангуулж өгнө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>426,909,783.86</u></b>	<b><u>341,209,483.57</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	21,520.00	15,981,747.76
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	21,520.00	20,462.76
31110	Төгрөг	21,520.00	20,462.76
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	15,961,285.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	15,961,285.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	8,050,224.00	10,257,440.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	8,050,224.00	10,257,440.00
3351	Байгууллагаас авах авлага	8,050,224.00	10,257,440.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	24,637,719.00	24,637,719.00
34600	Урьдчилж гарсан зардал	24,637,719.00	24,637,719.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	394,200,320.86	290,332,576.81
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	394,200,320.86	290,332,576.81
35410	Бичиг хэргийн материал	71,846,308.30	79,341,977.30
35420	Аж ахуйн материал	267,894,012.56	193,900,599.51
35440	Түлш, шатах тослох материал	54,460,000.00	17,090,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>16,283,756,357.40</u></b>	<b><u>15,566,366,415.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>16,283,756,357.40</u></b>	<b><u>15,566,366,415.85</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>15,752,321,156.50</u></b>	<b><u>15,118,314,085.55</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,671,024,219.00	12,671,024,219.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-633,551,211.00	(844,734,948.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	305,057,700.00	390,682,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-212,852,839.15	(316,516,033.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,454,023,455.00	4,399,290,689.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,265,209,512.68	(1,610,129,275.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	870,408,675.00	928,814,612.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-450,382,931.67	(513,921,479.50)
39217	Ном	13,803,602.00	13,803,602.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>531,435,200.90</u></b>	<b><u>448,052,330.30</u></b>
39301	Програм хангамж	204,590,292.00	214,952,292.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,310,471.10	(128,219,529.78)
39303	Бусад биет бус хөрөнгө	427,155,380.00	427,155,380.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(65,835,811.92)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>16,710,666,141.26</u></b>	<b><u>15,907,575,899.42</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>16,710,666,141.26</u></b>	<b><u>15,907,575,899.42</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	16,710,666,141.26	15,907,575,899.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,503,228,121.26	2,503,228,121.26
51101	Өмч: - төрийн	2,503,228,121.26	2,503,228,121.26
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>12,245,204,861.36</u></b>	<b><u>11,442,114,619.52</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	12,245,204,861.36	12,245,204,861.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(803,090,241.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,962,233,158.64	1,962,233,158.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>16,710,666,141.26</u></b>	<b><u>15,907,575,899.42</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,557,678,534.00</b>	<b>3,608,009,733.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>261,264,195.00</b>	<b>348,127,733.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	261,264,195.00	348,127,733.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	261,264,195.00	348,127,733.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	346,723,033.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	256,548,795.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,715,400.00	1,404,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,296,414,339.00</b>	<b>3,259,882,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,188,964,900.00	3,254,882,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,099,964,900.00	3,254,882,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	89,000,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	107,449,439.00	00.00
131105	Нэмэлт санхүүжилт	00.00	5,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	107,449,439.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,025,841,190.07</b>	<b>4,411,099,974.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,868,000,838.12</b>	<b>4,191,767,145.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,868,000,838.12</b>	<b>4,191,767,145.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,112,589,877.86</b>	<b>2,165,654,815.00</b>
210101	Үндсэн цалин	813,809,076.00	1,003,428,200.00
210102	Нэмэгдэл	337,160,700.00	439,210,164.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,260,201.66
210104	Урамшуулал	148,421,100.00	58,481,049.00
210105	Гэрээт ажлын хөлс	648,488,801.86	500,275,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>247,231,932.85</b>	<b>286,368,384.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	182,618,098.85	217,600,612.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,088,283.00	17,522,964.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,261,655.00	14,181,433.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,151,786.00	3,387,122.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,112,110.00	33,676,253.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>246,114,777.34</b>	<b>223,481,243.15</b>
210301	Гэрэл, цахилгаан	58,119,532.00	62,490,550.00
210302	Түлш, халаалт	155,000,000.00	123,867,748.75
210303	Цэвэр, бохир ус	32,995,245.34	37,122,944.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>170,296,317.63</b>	<b>267,628,142.32</b>
210401	Бичиг хэрэг	82,334,515.63	68,844,598.00
210402	Тээвэр, шатахуун	28,838,110.00	55,174,500.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	21,317,969.49	18,974,116.47
210404	Ном, хэвлэл	321,950.00	5,285,295.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,421,580.00	12,505,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,062,192.51	81,984,153.85
210408	Бараа материал акталсны зардал	00.00	24,860,479.00

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>75,227,411.00</b>	<b>98,367,695.59</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,850,000.00	00.00
210604	Урсгал засвар	70,377,411.00	98,367,695.59
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>44,479,945.00</b>	<b>103,991,860.00</b>
210701	Гадаад албан томилолт	10,256,710.00	36,000,912.00
210702	Дотоод албан томилолт	25,784,590.00	60,434,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,438,645.00	7,556,648.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>92,551,145.00</b>	<b>156,888,094.39</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,015,090.00	99,109,215.15
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	5,940,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,446,400.00	3,436,848.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	796,200.00	253,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,166,090.00	10,917,000.00
210807	Газрын төлбөр	4,968,600.00	8,968,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	1,057.24
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,208,765.00	28,261,974.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>879,509,431.44</b>	<b>889,386,910.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,052,610.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,410,554.00	42,644,262.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	805,046,267.44	846,742,648.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>157,840,351.95</b>	<b>219,332,829.64</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,045,000.00</b>	<b>4,866,000.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,045,000.00	4,866,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,959,130.00</b>	<b>41,462,256.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,808,130.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	32,837,256.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,151,000.00	8,625,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>98,836,221.95</b>	<b>173,004,573.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,836,221.95	173,004,573.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-468,162,656.07</b>	<b>-803,090,241.84</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>296,861,914.59</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	296,861,914.59	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-296,861,914.59</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(765,024,570.66)</b>	<b>(803,090,241.84)</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,552,003,134.00</b>	<b>3,606,605,033.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>255,588,795.00</b>	<b>346,723,033.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	255,588,795.00	346,723,033.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	255,588,795.00	346,723,033.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	346,723,033.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	255,588,795.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,296,414,339.00</b>	<b>3,259,882,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,188,964,900.00	3,254,882,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,099,964,900.00	3,254,882,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	89,000,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	107,449,439.00	5,000,000.00
131105	Нэмэлт санхүүжилт	00.00	5,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	107,449,439.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,358,704,776.00</b>	<b>3,532,370,535.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,358,704,776.00</b>	<b>3,532,370,535.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,201,015,424.05</b>	<b>3,313,037,705.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,102,880,734.71</b>	<b>2,165,654,815.00</b>
210101	Үндсэн цалин	889,662,735.00	1,003,428,200.00
210102	Нэмэгдэл	337,160,700.00	439,210,164.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,260,201.66
210104	Урамшуулал	148,421,100.00	58,481,049.00
210105	Гэрээт ажлын хөлс	562,925,999.71	500,275,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>243,612,400.00</b>	<b>279,311,600.00</b>
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	243,612,400.00	279,311,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>246,114,777.34</b>	<b>223,481,243.15</b>
210301	Гэрэл, цахилгаан	58,119,532.00	62,490,550.00
210302	Түлш, халаалт	155,000,000.00	123,867,748.75
210303	Цэвэр, бохир ус	32,995,245.34	37,122,944.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>169,137,716.00</b>	<b>176,528,500.00</b>
210401	Бичиг хэрэг	37,975,709.00	45,778,134.00
210402	Тээвэр, шатахуун	44,110,460.51	17,804,500.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	22,720,469.49	18,974,116.47
210404	Ном, хэвлэл	8,849,470.00	32,936,353.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,496,940.00	14,186,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,984,667.00	46,848,846.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,268,000.00</b>	<b>6,268,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,268,000.00	6,268,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>69,638,800.00</b>	<b>113,592,100.59</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,797,509.00	22,008,000.00
210604	Урсгал засвар	59,841,291.00	91,584,100.59

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>78,351,300.00</b>	<b>105,190,210.00</b>
210701	Гадаад албан томилолт	10,556,710.00	36,000,912.00
210702	Дотоод албан томилолт	42,784,590.00	60,434,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,010,000.00	8,754,998.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>216,691,490.00</b>	<b>199,908,036.86</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,007,290.00	111,619,601.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	5,940,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,446,400.00	3,436,848.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	796,200.00	253,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	54,273,000.00	16,428,530.00
210807	Газрын төлбөр	4,968,600.00	8,968,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	1,057.24
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	73,260,000.00	53,260,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>68,320,206.00</b>	<b>43,103,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,207,610.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,112,596.00	43,103,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>157,689,351.95</b>	<b>219,332,829.64</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,045,000.00</b>	<b>4,866,000.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,045,000.00	4,866,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,808,130.00</b>	<b>41,462,256.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,808,130.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	32,837,256.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	8,625,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>98,836,221.95</b>	<b>173,004,573.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,836,221.95	173,004,573.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>193,298,358.00</u></b>	<b><u>74,234,497.76</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>201,433,784.00</b>	<b>58,274,270.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>201,433,784.00</b>	<b>58,274,270.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>201,433,784.00</b>	<b>58,274,270.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	201,433,784.00	58,274,270.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-201,433,784.00</u></b>	<b><u>-58,274,270.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-8,135,426.00</b>	<b>15,960,227.76</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>8,156,946.00</b>	<b>21,520.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>21,520.00</b>	<b>15,981,747.76</b>



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,076,072,741.26	1,962,233,158.64	13,010,229,432.02	<b>17,048,535,331.92</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	2,076,072,741.26	1,962,233,158.64	13,010,229,432.02	<b>17,048,535,331.92</b>
Тайлант үеийн үр дүн	427,155,380.00	00.00	(765,024,570.66)	<b>(337,869,190.66)</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,503,228,121.26	1,962,233,158.64	12,245,204,861.36	<b>16,710,666,141.26</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	2,503,228,121.26	1,962,233,158.64	12,245,204,861.36	<b>16,710,666,141.26</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(803,090,241.84)	<b>(803,090,241.84)</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,503,228,121.26</b>	<b>1,962,233,158.64</b>	<b>11,442,114,619.52</b>	<b>15,907,575,899.42</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,499,882,000.00</b>	<b>3,417,640,231.60</b>	<b>82,241,768.64</b>	97.65
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,499,882,000.00</b>	<b>3,417,640,231.60</b>	<b>82,241,768.64</b>	97.65
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,391,873,700.00</b>	<b>3,366,311,975.60</b>	<b>25,561,724.40</b>	99.72
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,181,616,100.00</b>	<b>2,165,654,815.00</b>	<b>(5,961,285.00)</b>	99.24
210101	Үндсэн цалин	1,003,248,200.00	1,003,428,200.00	180,000.00	100.02
210102	Нэмэгдэл	438,940,200.00	439,210,164.34	269,964.34	100.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,710,200.00	164,260,201.66	449,998.34	99.73
210104	Урамшуулал	74,442,300.00	58,481,049.00	19,961,251.00	78.55
210105	Гэрээт ажлын хөлс	500,275,200.00	500,275,200.00	0.00	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>279,311,600.00</b>	<b>279,311,600.00</b>	<b>0.00</b>	100.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	279,311,600.00	279,311,600.00	89,379,700.00	147.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>230,984,100.00</b>	<b>223,481,243.15</b>	<b>7,502,856.85</b>	96.75
210301	Гэрэл, цахилгаан	69,633,900.00	62,490,550.00	7,143,350.00	89.74
210302	Түлш, халаалт	124,227,300.00	123,867,748.75	359,551.25	99.71
210303	Цэвэр, бохир ус	37,122,900.00	37,122,944.40	-44.40	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>177,692,000.00</b>	<b>177,692,000.00</b>	<b>0.00</b>	100.00
210401	Бичиг хэрэг	44,150,900.00	45,778,134.00	627,234.00	103.69
210402	Тээвэр, шатахуун	17,827,000.00	17,804,500.00	22,500.00	99.87
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	19,216,000.00	18,974,116.47	241,883.53	98.74
210404	Ном, хэвлэл	34,205,800.00	32,936,353.53	1,269,446.47	96.29
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,280,000.00	14,186,550.00	93,450.00	99.35
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,012,300.00	48,012,346.00	-46.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,268,000.00</b>	<b>6,268,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,268,000.00	6,268,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>121,120,400.00</b>	<b>120,961,400.59</b>	<b>158,999.41</b>	<b>99.87</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,400,000.00	29,377,300.00	22,700.00	99.92
210604	Урсгал засвар	91,720,400.00	91,584,100.59	136,299.41	99.85
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>105,197,300.00</b>	<b>105,190,210.00</b>	<b>7,090.00</b>	<b>99.99</b>
210701	Гадаад албан томилолт	36,000,900.00	36,000,912.00	(12.00)	100.00
210702	Дотоод албан томилолт	60,434,300.00	60,434,300.00	0.00	100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,762,100.00	8,754,998.00	7,102.00	99.92

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>246,581,000.00</b>	<b>244,649,506.86</b>	<b>1,931,493.14</b>	<b>99.21</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,219,400.00	106,619,601.62	599,798.38	99.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,940,000.00	5,940,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,446,500.00	3,436,848.00	9,652.00	99.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,576,500.00	253,400.00	1,323,100.00	16.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,170,000.00	66,170,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	8,968,600.00	8,968,600.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	1,057.24	(1,057.24)	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,260,000.00	53,260,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43103200.00</b>	<b>43,103,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	43,103,200.00	43,103,200.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>108,008,300.00</b>	<b>51,328,256.00</b>	<b>61,680,044.00</b>	<b>42.89</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>4,957,200.00</b>	<b>4,866,000.00</b>	<b>91,200.00</b>	<b>98.16</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,957,200.00	4,866,000.00	91,200.00	98.16
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>103,051,100.00</b>	<b>46,462,256.00</b>	<b>61,588,844.00</b>	<b>40.23</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,701,100.00	32,837,256.00	59,863,844.00	35.42
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,350,000.00	8,625,000.00	1,725,000.00	83.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,000,000.00	(5,000,000.00)	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,576,870,500.00</b>	<b>3,433,600,459.36</b>	<b>(143,270,040.64)</b>	<b>100.69</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,331,870,500.00</b>	<b>3,188,600,459.36</b>	<b>(143,270,040.64)</b>	<b>95.54</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,331,870,500.00	3,188,600,459.36	(143,270,040.64)	95.54
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>245,000,000.00</b>	<b>245,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000,000.00	245,000,000.00	00.00	00.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>21,520.00</b>	<b>(21,520.00)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>15,981,747.76</b>	<b>(15,981,747.76)</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>207</b>	<b>207</b>	<b>0</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	3	3	0	100.00

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	95	95	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	9	9	0	100.00
620004	Гэрээт ажилтан	100	100	0	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	24	24	0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	83	83	0	100.00
650010	Гэрээт ажилтан	100	100	0	100.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,000,000.00
Дүн	00.00	5,000,000.00

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:

2020-02-10

Аудитын нэр:

*Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код:

САГ-2020/36/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

*Архивын ерөнхий газар*

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт урсгал зардлыг буруу тайлагнасан.	15,961.3	Залруулсан	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
2	Үр дүнгийн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлого нь мөнгөн гүйлгээний тайлангийн орлогоос зөрүүтэй байсныг залруулсан. Орлогоо давхар бүртгэсэн байсан.	15,000.0	Залруулсан	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
3	Хангамжийн материалын оны эцсийн тооллогын бүртгэлийг тулган шалгахад эд хогшил, тоног төхөөрөмжийг хангамжийн материалд бүртгэсэн байсныг залруулсан.	71,078.4	Залруулсан	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
4	АЕГ азар нь 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 25.5 сая төгрөгийн шатахуун илүү нөөцөлсөн байсан ба 2019 онд нэмж 15.8 сая төгрөгийн шатахуун худалдан авч, оны эцэст 17.1 сая төгрөгийн шатахуун илүү нөөцөлсөн байна.	17,090.0	Албан шаардлага	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
5	Зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1. 2019 оны 12.20-нд шилжүүлсэн цэвэрлэгээний материал 2.1 сая төгрөг 2. 2019 оны 12 сарын 25-нд шилжүүлсэн материалын үнэ 4.0 сая төгрөг материалын нэр тоо ширхэг, нэг бүрийн үнэ байхгүй бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн.	6,099.2	Зөвлөмж	Архивын ерөнхий газрын дарга, Санхүү аж ахуй хэлтсийн дарга	С.Энхбаатар, Б.Цэвэлмаа
	<b>Дүн</b>	<b>125,228.9</b>			



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 06 № 02/03

Улаанбаатар хот

СЯГ-2020/36/СТЭ ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацааны дагуу Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Архивын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлангаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс тайлант онд 15,800.0 мянган төгрөгийн шатахууныг нэмж бэлтгэн, оны эцэст 17,090.0 мянган төгрөгийн шатахуун илүү нөөцөлсөн байна.

Энэ нь “Үнэн зөв” батламж мэдэгдэл, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...,” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, бараа материалын зохистой үлдэгдлийг хангаж ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Цэвэлмаа нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

#### ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Д.ЦЭГМИДДОРЖ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦӨТГӨСӨН:

СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ В.ДАВААСҮРЭН

АУДИТОР Д.МОНГОЛШИШАА ЦЭРЭНЧИМЭД

#### ЗӨВШӨӨРСӨН:

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБААТАР

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЦЭВЭЛМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангаснаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь таллах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

